



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын  
бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бие  
бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 2 дахь заалт, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135, 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг 2019 оны 05 дугаар сарын 24-нөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд оролцуулсугай.

2. Бүтээн байгуулалтын ажилд оролцох "Замын хээрийн ... дугаар тусгай анги"-ийг байгуулан, бие бүрэлдэхүүн, техник, тоног төхөөрөмж, шаардагдах бусад хэрэгслэлээр хангахыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал А.Ганбат/-т даалгасугай.

3. Бүтээн байгуулалтын ажилд оролцох бүрэлдэхүүнийг тасралтгүй удирдлагаар ханган, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон бусад стандарт, шаардлагыг холбогдох дүрэм, журмын дагуу хатуу мөрдүүлэн, уг ажлыг чанарын өндөр төвшинд, тогтоосон хугацаанд нь гүйцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга /хошууч генерал А.Ганбат/-д хариуцуулсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Д.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

САЙД



Н.ЭНХБОЛД

